



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Аравайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.18 № 34  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


## Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / .... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Баян-Өндөр сумын Монгол Ардын Намын Хорооны тэргүүлэгчдийн  
2020 оны 06-р сарын 17-ны өдрийн хуралдааны А/01-р тогтоолын хавсралт

2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БАЯН-ӨНДӨР СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Эрүүл мэндийн үйлчилгээ-эрүүл иргэн**

1.1.1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.1.2 Сумын иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, бүх шатлалын эмнэлэгүүдэд мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлэх.

1.1.3. Сумын Эрүүл Мэндийн Төвийг шаардлагатай эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, эмч нарын ур чадварыг дээшлүүлж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах

1.1.4 "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлж 0-5 насны хүүхдийн шүдийг эрүүлжүүлэх

1.1.5 Эрүүл Мэндийн Төвийн үйл ажиллагааг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний чиглэлээр өргөжүүлнэ.

1.1.6 Уламжлалт эмчилгээний кабинет байгуулах, сэргээн засах, эмийн бус аргаар эрүүлжүүлэх үйлчилгээг тогтмолжуулах

1.1.7 Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих

**Чанартай боловсрол**

1.4.1 Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хүүхэд харах үйлчилгээг дэмжиж, цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ.

1.4.2. ЕБС-ийн спорт заал засварлах, сургуулийн болон дотуур байрны гадна болон дотор талын ариун цэврийн байгууламжуудыг шинэчлэх хүүхэд сурч хөгжих таатай орчин бүрдүүлнэ

1.4.3 Нүхэн жорлонтой цэцэрлэг, дотуур байруудыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй өрөөтэй болгох. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ

1.4.4 Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол, ур чадварыг дэмжсэн "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлж, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах

1.4.5 ЕБСургуулийн 320 хүүхдийн хичээлийн шинэ байр барих

1.4.6 Цэцэрлэг, дотуур байрын сурагчдын хоолны шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

**Тогтвортой амар амгалан гэр бүл**

19

1.5.1 Залуучуудыг амьдралын зөв дадалд сургах, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, амралт, чөлөөт цагийн чиглэл бүхий “Залуучуудын хөгжлийн төв”-ийг сумын соёлын төвийн дэргэд байгуулах.

1.5.2 “Хүүхдэд ээлтэй сум” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх хүүхдийн, спорт тоглоомын талбайнуудыг шинээр бий болгоно.

1.5.3. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ахмадуудад зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн болон чөлөөт цагийн танхим байгуулж ажиллуулна.

1.5.4 Ахмадын өргөөг шинээр байгуулах

#### **Үндэсний бахархал, өв соёл, спорт**

1.6.1 Соёлын төвийн материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг зайны болон нүүдлийн хэлбэрт оруулан, хөгжим, бүжгийн мэргэжлийн багшаар бүрэн хангаж соёлын үйлчилгээг сайжруулна.

1.6.2 Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өргөжүүлж, биеийн тамир спортыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх санал санаачлагыг дэмжинэ

1.6.3 Орон нутаг судлах музейн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн соёлын өв сурталчилах төв болгох.

1.6.4 Соёлын төвийн барилга шинээр барих

#### **Хүнс Хөдөө аж ахуй, Хөдөлмөр эрхлэлт**

2.2.1. Сумын нийт мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, чанартай малтай малчдыг урамшуулах тогтолцоог бий болгох, залуу малчдыг бэлтгэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх.


2.2.2. Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулах

2.2.3. Бэлчээрийг хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах

2.2.4. Мал, амьтны гаралтай халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бус болгох.

2.4.5. Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах.

2.4.6. Нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх. 2.4.7. Олон гишүүнтэй хамтын хоршоо байгуулахад



дэмжлэг үзүүлж улмаар хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл- үйлчилгээг бий болгож ажлын байрыг нэмэгдүүлнэ

2.4.8. Ажлын байр нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрийг дэмжих

2.4.9. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх.

1.4.10. Бөмбийд ногоон тэжээл тариалалтыг нэмэгдүүлж, аюулгүй нөөцийн фондоо бүрдүүлдэг болох

### **Засаглалын бодлого**

3.1.1. Төрийн албан хаагчийн цалинг иргэдэд үзүүлсэн ажлын бүтээмж, үйлчилгээний чанартай нь уялдуулж олгодог зарчим нэвтрүүлж, иргэдийн үнэлгээ өгдөг тогтолцоог боловсронгуй болгоно.

3.1.2 төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар. Хандлагыг эрс шинэчилнэ.

3.1.3. Төрийн байгууллагын бүх шатанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхолын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **Хууль эрх зүй, аюулгүй амьдрал**

3.4.1. Хүний эрх, үүргийн нэгдлийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, эрх зүйн туслалцааны бие даасан үйлчилгээг бий болгох.

3.4.2 Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулж, орон байрын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.

3.4.3. Орон нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрх, эрх чөлөө, иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахын өмнө иргэд, хуулийн этгээд, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тэдгээрээс гаргасан саналуудыг тухайн гарах шийдвэрт тусгаж, эргэн мэдээлэх асуудлыг журамлаж хэрэгжүүлнэ.

### **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

4.1.1 сумын төвийн хүн амыг баталгаат ундны усаар хангах

4.1.2 Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ

4.1.3 Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготоно мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж. Холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ

4.1.4 Бэлчээрийг нөхөн сэргээх Малчдын дундын сан-г бий болгох

4.1.5 Өрхийн хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэх

21

#### **4.5.Хот байгуулалт, дэд бүтэц**

- 4.5.1 Сумын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын орчин үеийн эко хотхоны үзэл баримтлалаар хөгжүүлэх бодлого баримтлана.
- 4.5.2. Шинээр байгуулах гэр хорооллын дэд бүтцийг шийдвэрлэх
- 4.5.3 Үйлчилгээний стандартын шаардлага хангасан үсчин, гоо сайхны үйлчилгээг тогтмолжуулах
- 4.5.4. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан худалдааны төвтэй болох
- 4.5.5. Үйлчилгээний стандартын шаардлага хангасан буудал, кафе зоогийн газартай болох
- 4.5.6 Төвлөрсөн инженерийн шугам сүлжээг байгуулах
- 4.5.7 халуун усны барилга. Бохирын цооногийг стандартад нийцүүлэх

**БАЯН-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ ӨРДҮН НАМЫН ХОРОО**



*[Handwritten signature]*